

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Булган аймгийн
Төрийн аудитын газар

Тэргүүлэх Аудитор
Д.Анхбаяр

Аудитын менежер
Ж.Энхцоодол

Ахлах аудитор
Г.Ганбаатар

Аудитор
П.Мөнхтуяа

2018 оны 4 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зййл байвал
70342495 дугаарын утас,
70342580 дугаарын
факсаар харилцана уу.

Цахим хаяг:
Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгсийн жагсаалт 1

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 2

Бүлэг А. Хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлого, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөсөн ч барилгын ажил удааширалтай, шинээр аймагт хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдөөгүй байна.

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна. 6

А.2 Шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна. 6

А.3 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байна. 7

Бүлэг Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналт сул, гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн, хангалтгүй хэрэгжиж байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хуулийн дагуу зохион байгуулагдсан орон нутагт эрх шилжиж ирээгүй, БСШУС-ын яаман дээр зарлагдсан 7

Б.2. Төсөл, арга хэмжээний зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан ч магадлагаагаар зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна. 7

Б.3. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна. 8

Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт сул гэрээний хугацаа хэтэрсэн байна. 9

Б.4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн гэрээний хугацаа хэтэрсэн, төсөвт өртөг нэмэгдсэн байна. 9

Б.4.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн их засварын зарим ажлын гэрээний хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй байна. 15

Дүгнэлт 19

Зөвлөмж 21

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
БТХ	Барилгын тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАЗГ	Тээвэр авто замын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалт газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

2018.04.12.

Булган

1.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2.Аудитын зорилт:

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд,үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх,

3.Хамрах хүрээ:

Аудитад улсын төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилтийг болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болох аймгийн Өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн тендерийн баримт бичиг, гэрээ, гүйцэтгэл, мэдээ, тайланд тулгуурлан хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулсан.

4.Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, холбогдох судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

5.Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Төсвийн хүрээний мэдэгдэл
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”

6. Аудит хийх хугацаа

Аудитын төлөвлөлт, хөтөлбөрийг хийх, арга зүйг боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлж нотлох баримтыг хангах, олон нийтэд мэдээлэх зэрэгт 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ажлын 24 хоногт багтаан гүйцэтгэлээ.

7. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдан, ахлах аудитор Г.Ганбаатар аудитор П.Мөнхтуяа нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Булган аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 16971.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 3532.3 сая төгрөг батлагдаж, 2017 онд 6 төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эрх нээж, төрийн сангаас гүйцэтгэлээр 3532.3 сая төгрөгний 5 барилгын ажлыг Сангийн яамнаас шууд санхүүжүүлж, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар аймгийн Засаг даргын тамгын газрын барилга 153.9 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн байна.

Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан нийт хөрөнгө оруулалтын 57,9 хувь буюу 9826.4 сая төгрөгийг сургууль, цэцэрлэг барьж өргөтгөх, 7,6 хувь буюу 1290.0 сая төгрөгийг соёлын төв барих ажилд, 10,1 хувь буюу 1717.5 сая төгрөгийг спортын заалын барих ажилд зарцуулж Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын сайдын, 24.4 хувь буюу 4137.5 сая төгрөгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, сайд нарын багцаас санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймагт баригдаж байгаа 16971.6 сая төгрөгний төсөвт өртөгтэй 6 барилгын 4137.5 сая төгрөг буюу 1 арга хэмжээ 2011 оноос, 12833.9 сая төгрөг буюу 5 арга хэмжээ 2012 оноос хэрэгжиж байгаа, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төслийн төлөвлөгөөнд шинэ барилга тусгаагүй, 2013-2017 онд шинээр нэг ч барилга нэмэгдэж баригдаагүй, төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Манай аймагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилгын ажлын санхүүжилтэнд 2017 онд төв төрийн сан дахь данснаас ЗГХЭГ-ын Сайдын хөрөнгө оруулалтаас 153.9 сая төгрөг аймагт эрх шилжин ирж хяналт тавьж ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлсэн.

Булган аймагт 2017 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын төсөл, арга хэмжээний 7 ажлыг 411.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 оноос хойш баригдаж байгаа Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил 45 хувьтай, 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтанд санхүүжилт суугаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 16971.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 3532.3 сая төгрөг батлагдсан.

Аймгийн Засаг даргын тамгын газрын барилга анхны төсөвт өртөг 2954.5 сая төгрөг нийт 4817.9 сая төгрөгөөр гүйцэтгэж 1863.4 сая төгрөгөөр, Булган сумын сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга 2663.7 сая төгрөг нийт 4186.4 сая төгрөгөөр гүйцэтгэж 1522.7 сая төгрөгөөр, Булган сумын цэцэрлэгийн 150 хүүхдийн барилга 800.0, сая төгрөг нийт 1340.0 сая төгрөгөөр гүйцэтгэж 540.0 сая төгрөгөөр, Баян-Агт сумын соёлын төв 700.0 сая төгрөг нийт 1290.0 сая төгрөгөөр гүйцэтгэж 590.0 сая төгрөгөөр, Хялганат тосгоны спортын заал 1100.0 сая төгрөг нийт 1717.5 сая төгрөгөөр гүйцэтгэж 617.5 сая төгрөгөөр тус тус анхны төсөвт өртөг нэмэгдэж, гэрээний хугацааг 3-4 жил хэтрүүлсэн байна.

Төрийн аудитын газар

Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Бүлэг А

Хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлого, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөсөн ч барилгын ажил удааширалтай, шинээр аймагт хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдөөгүй байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж нь анх 2010 онд аймгийн ИТХ-ын VI хуралдааны 06/01 тогтоолоор “Булган аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/”-ыг батлаж, аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан барилгын салбарыг хөгжүүлэх, шинээр барих объект, их засварын ажил, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн жил, жилийн төсөв, нийгэм-эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны болон

жил бүрийн үндсэн чиглэлд тусган, хэрэгжүүлж нэгдсэн бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

А.2. Шаардлага хангасан, төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд Булган аймагт хэрэгжиж байгаа 16971.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг анх 2010 оноос эхлэн нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын жагсаалтыг гаргаж, сумын тамгын газар, эмнэлэг, сургууль, урлаг спортын барилга байгууламжыг шинээр барьж байгуулах, өргөтгөх ажлыг Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган шат дараатай авч хэрэгжүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд барилга байгууламж нь ТЭЗҮ-тэй, зураг төсөл хийгдсэн хуулийн шаардлага хангасан орон нутгаас санаачлан сургуулийн хүчин чадал хүүхдийн суудлын тоог нэмэгдүүлэх, сурах орчинг сайжруулах, урлаг соёл, спортын үйлчилгээг иргэдэд хүргэх нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөлтийг үндэслэлтэй хийж орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн аймгийн хөгжлийн цогц бодлого болон салбарын бодлоготой уялдуулж төлөвлөсөн байна.

А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байна.

Аймагт баригдаж байгаа барилга байгууламжийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахдаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж, аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан газрын зөвшөөрлийг авч, барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг хийж батлуулан тухай жилийн төсвийн төсөлд тусгуулан бэлтгэл ажлыг хангасан байна.

Төрийн аудитын газар	Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
Бүлэг Б	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналт сул, гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн, хангалтгүй хэрэгжиж байна.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хуулийн дагуу зохион байгуулагдсан, орон нутагт эрх шилжиж ирээгүй БСШУС-ын яаман дээр зарлагдсан.

Аймгийн ЗДТГ-ын конторын барилгын зураг төсвийг 2011 онд “Өрх” ХХК –иар хийлгүүлэн 2984.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр орон нутагт тендер зарлан 3 компани оролцож гүйцэтгэгчээр “Түмэн-Алт” ХХК 2954.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр шалгарсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд үргэлжлүүлэн хэрэгжиж байгаа Булган сумын 150 ортой цэцэрлэгийн, 640 хүүхдийн суудалтай 1-р сургуулийн, 640 хүүхдийн суудалтай сургуулийн, Хангал сумын Хялганат тосгоны

биеийн тамирын заал, Баян-Агт сумын соёлын төвийн барилгын тендерүүд бүгд БСШУСЯаман дээр тендерийн сонгон шалгаруулалт зарлагдсан орон нутагт эрх шилжиж ирээгүй байна.

Б.2. Төсөл, арга хэмжээний зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан ч магадлагаагаар зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Булган сумын 150 ортой цэцэрлэгийг “Бат проек” ХХК, 640 хүүхдийн суудалтай 1-р сургуулийг “Өлзий иш” ХХК, 640 хүүхдийн суудалтай сургуулийг “Бак” ХХК, Хангал сумын Хялганат тосгоны биеийн тамирын заалыг, Баян-Агт сумын соёлын төвийг “Өрх” ХХК зураг төсвийг тус тус тухайн үед хийж боловсруулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төсөвт өртөг нэмэгдсэн зэрэг шалтгаанаар магадлалаар орж зураг төсвийн үнийг нэмсэн боловч барилгын ажил удаашрилтай байна.

Б.3. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна.

Аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 6 барилга нь анх гэрээ байгуулагдсанаас хойш 4-5 жилээр хугацаа хэтэрсэн, 2017 онд их засварын 7 ажил тусгагдсанаас гурван их засварын ажил нь хугацаандаа хэрэгжээгүй, гэрээний дагуу алданги болон хариуцлага тооцоогүй байна. Үүнд:

Булган сумын 150 ортой цэцэрлэг, 640 хүүхдийн суудалтай 1-р сургууль, 640 хүүхдийн суудалтай сургууль, Хангал сумын Хялганат тосгоны биеийн тамирын заал, Баян-агт сумын соёлын төв, Тэшиг сумын сургуулийн барилгууд нь олон жил удааширч хугацаандаа хэрэгжээгүй байна.

Мөн их засварын ажлуудаас Могод сумын Соёлын төвийн их засварын ажлын гэрээг 2017 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс хойш 60 хоногийн дотор гүйцэтгэхээр “Элэг бүс” ХХК-тай гэрээ байгуулж хугацаандаа дуусаагүй 41 хоногоор, Дашинчилэн сумын 320 хүүхдийн суудалтай бүрэн дунд сургуулийн барилгын дээврийн завсрын ажлыг УБ хотын “Онъ тэнгэрийн бичиг” ХХК 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулж хугацааг 22 хоногоор, Нэгдсэн эмнэлгийн А блокны засварын ажлыг “Бүлээн оргил” ХХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 30 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч 38 хоногоор тус тус хэтрүүлж гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй, гэрээнд тусгай нөхцөлийг тусгаагүй, хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлага болон алданги тооцох талаар тусгаж гэрээ байгуулаагүй байна.

Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт сул гэрээний хугацаа хэтэрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийхэд барилга байгууламжийг гэрээний дагуу чанартай, хугацаанд нь гүйцэтгээгүй, гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй, хөрөнгө оруулалтын ажлууд хангалтгүй үр дүн муутай зохион байгуулагдаж байна.

Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд Булган аймагт шинээр 1 ч төсөл, арга хэмжээ нэмж тусгагдаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон

жил он дамжин хэрэгжиж байгаа 6 төсөл арга хэмжээг 2017 онд санхүүжүүлэхээр төсөвт тусгаж, төрийн сангаас 16971.6 сая төгрөгний барилга байгууламжийг санхүүжүүлсэн, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсан аймгийн Засаг даргын тамгын газрын барилга 153.9 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, их засварын 7 ажлын эрх аймгийн Засаг даргад шилжиж ирсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хяналт тавьж ажилласнаар Булган аймгийн Засаг даргын тамгын газрын контор, 150 ортой цэцэрлэг, 640 хүүхдийн суудалтай сургууль, Хялганат тосгоны биеийн тамирын заал, Баян-Агт сумын соёлын төв барилга зэрэг 4 төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ажил дууссан, их засварын ажлуудыг 2017 онд багтаан хэрэгжүүлэн ажиллажээ.

Б.4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн гэрээний хугацаа хэтэрсэн, төсөвт өртөг нэмэгдсэн байна.

III.1.2. Булган аймгийн засаг даргын тамгын газрын барилга:

Аймгийн ЗДТГ-ын конторын барилгын зураг төсвийг 2011 онд “Өрх” ХХК –иар хийлгүүлэн 2984.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр тендер зарлан гүйцэтгэгчээр “Түмэн-Алт” ХХК 2954.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр шалгарч, 2011 оны 9-р сарын 15-ны өдрөөс эхлэн 2012 оны 12 дугаар сард бүрэн дуусгахаар гэрээ байгуулсан боловч одоог хүртэл дуусаагүй.

Гэрээгээр 2954,5 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр болсон боловч Улсын төсөвт 2345.0 сая төгрөгийн төсөв батлагдан 609.5 сая төгрөг дутуу батлагдсан.

“Түмэн-Алт” ХХК-тай байгуулсан гэрээнд 2011 онд тусгагдсан хөрөнгөнөөс нэмэлт хөрөнгө шаардагдсан тохиолдолд гүйцэтгэгч байгууллага өөрийн хөрөнгөөр санхүүжилтээ хийж ажиллан 2012 оны 12-р сард багтаан дуусгахаар тусгажээ.

2011 онд УТХО-аар 40.0, ОНТХО-аар 100.0 сая, 2012 онд 1800.0 сая, 2013 онд 505.0 сая төгрөг батлагдан ажлын үе шатны гүйцэтгэлийг хянаж 2011 онд орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 140.0 сая, 2012 онд улсын төсвөөс гүйцэтгэгч компанид 1765.0 сая төгрөг, ГХБХБГ-т 3.0, Өрх ХХК-д зохиогчийн хяналтын зардалд 6.8 сая, зураг төсвийн үнэнд 13.0 сая, нийт 1927.8 сая, 2013 онд Сангийн яамнаас шууд 350.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгон бүгд 2277.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Барилгын ажлын санхүүжилтийг улсын төсөвт бүрэн төлөвлөж тусгаагүй, ажлын гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллагын хяналт сул, төлөвлөсөн хугацаандаа барилгын ажил дуусаагүй, гэрээний биелэлт хангалтгүй байна. Ажлыг гэрээний хугацаанд хийгээгүй, хяналт тавьж хариуцлага тооцож байгаагүйгээс барилгын материалын үнэ өссөн, журамд өөрчлөлт орж ажилчдын цалин хөлс, материалын зардал өссөн зэрэг шалтгаанаар санхүүжилт хүрэхгүй нэмэлт санхүүжилт шаардан 2014 онд барилгын ажил зогссон байна.

2015 онд ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181, 18 дугаар тогтоолыг үндэслэн ажлыг дахин магадлал оруулж төсвийг шинэчлэн батлуулан аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын ажлын санхүүжилтэнд 2015 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 331.7 сая төгрөг батлагдаж барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээг сунгасан, мөн 2015 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1148.3 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон, дахин 2016 оны 1 дүгээр улиралд ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулж Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 331.7

сая төгрөг авсан боловч барилгын ажил дуусаагүй, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 328.0, мөн аймгийн авто замын сангаас 109.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгож 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ашиглалтанд оруулж улсын комисс хүлээн авсан байна.

Гэтэл 2017 онд дахин улсын төсвийн хөрөнгө оруулалтанд 153.9 сая төгрөг батлуулж, аймагт эрх шилжин ирж 2017 оны 05 дугаар сарын 30-нд санхүүжилтийг бүрэн олгосон боловч хийсэн ажлын гүйцэтгэл тодорхойгүй, ажлын баримт байхгүй, шаардсан боловч гаргаж өгөөгүй, мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас аймгийн тамгын газрын “Г” блокны зураг төсвийн үнэ “Өрх” ХХК-д 11.8 сая төгрөг шилжүүлсэн, барилгын ажилд 137.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон боловч ямар ажил хийж гүйцэтгэсэн тодорхойгүй, ажлын гүйцэтгэл байхгүй, ажил хүлээлцээгүй зэрэг зөрчил илэрсэн тул мэргэжлийн байгууллагаар ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргуулж хуулийн байгууллагаар хянуулахаар шийдвэрлэсэн.

Уг барилга гэрээгээр 2012 онд ашиглалтанд орох ёстой даруй 5 жил хугацаа хоцорсон анхны төсөвт өртөг нь 2954.5 сая төгрөгөөр батлагдаж нийт 1863.4 сая төгрөг буюу 63.1 хувиар нэмэгдсэн, орон нутгийн төсвөөс нийт 1613.3, аймгийн авто замын сангаас 109.5, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3095.1 сая төгрөг бүгд 4817.9 сая төгрөгийн барилгын ажил хийгдэж улсын комисс хүлээж авсан барилгын ажлын чанар хангалтгүй байна.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /2018.03.30/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олон жил он дамжин хэрэгжиж байгаа 5 төсөл арга хэмжээг 2017 онд санхүүжүүлэхээр төсөвт тусгаж 3378.4 сая төгрөгний барилгын ажил хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Х.1.1.45. Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилга.

Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажилд 2012 онд 800.0 сая төгрөгийн төсөв батлагдаж 200.0 сая төгрөгийг 2012 онд, 600.0 сая төгрөгийг 2013 онд санхүүжүүлэхээр төсөвлөж тендерийг БСШУЯамнаас зарлаж гүйцэтгэгчээр “Чин ван констракшн” ХХК-ийг сонгон шалгаруулж 800.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Барилгын ажлыг 2012 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр эхлүүлж 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдөр дуусгахаар гэрээ байгуулан ажиллаж 2012 онд 71.5, 2013 онд 379.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компанид олгосон байна.

Барилгын ажлын гэрээг 2015 оны 02-р сарын 05-ныг хүртэл сунгасан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд 290.2 сая төгрөгний санхүүжилт олгосон ажлын гүйцэтгэлийг Барилгын хөгжлийн төвийн магадлалаар 540.3 сая төгрөгөөр нэмж төсвийг 1340.3 сая төгрөг болгож баталсан.

2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 300.2 сая төгрөгний санхүүжилт олгосон хийсэн ажлын гүйцэтгэл тодорхойгүй барилгын ажил дууссан улсын комисс хүлээж аваагүй байсан.

Булган сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтанд орж улсын комисс 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр барилгыг ашиглалтанд хүлээн авсан. Тухай комиссын хуралдаанаар “Чин Ван констракшн” компани дутуу хийсэн 47 ажлын жагсаалт гаргаж төсөвт багтаан хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн гэтэл 2017 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд 120.0 сая төгрөг тусгагдаж хэдий хэмжээний санхүүжилт олгосон, ямар ажил хийж гүйцэтгэсэн нь тодорхойгүй байна. “Чин ван констракшн” ХХК улсын комиссийн үүрэг болгосон барилгын ажлын дутуу 37 ажил хийгдээгүй, аймгийн ГХБХБГазар, БСШУС-ын сайдад удаа дараа шаардлага хүргүүлсэн боловч одоо хүртэл арга хэмжээ аваагүй байна..



/Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилга. 2016 он 12 сар/

Х.1.1.13. Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 1-р сургуулийн өргөтгөлийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 4300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын тендерийг БСШУЯ-аас зарлаж “Оффис констракшн” ХХК шалгарч 2014 оны 08-р сарын 22-ны өдрөөс 2016 оны 03-р сарын 30-нд барьж дуусгахаар гэрээ байгуулсан хугацаа хэтэрсэн. **2013-2015 онд**

2015 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 558.6 сая төгрөгний санхүүжилт олгосон ажлын гүйцэтгэл тодорхойгүй байсан.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2-р хавсралтаар доорхи санхүүжилтыг авсан. Үүнд:

XI.1.1.34. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 1207.9 сая төгрөгний санхүүжилт олгосон мөн,

X.1.1.24. Векселиэр мөн 2016 онд ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 214.3 сая төгрөг нэмж давхар авсан ажлын гүйцэтгэл тодорхойгүй, орон нутгийн ГХБХБГ-аас тодорхой хяналт тавиагүй нийт ажлын гүйцэтгэл тодорхойгүй байсан.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар доорхи санхүүжилтыг авсан. Үүнд:

X.1.1.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 800.0 сая төгрөгний санхүүжилт олгосон ажил график төлөвлөгөөний дагуу хийгдэж барилга угсралтын ажил нь каркасны ажил 100% дууссан бөгөөд гадна ханын дүүргэлт, дотор, гадна шавардлага, гадна шугам сүлжээний ажил хийгдээд байна. Гэрээнд өөрчлөлт оруулж 2017 оны 08-р сарын 20 хүртэл сунгасан ажил дуусаагүй, 2018 онд гэрээ сунгагдаагүй, ажил эхлээгүй байна. Аймгийн ГХБХБГ-аас барилгын ажилд хяналт тавьж нийт ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна.

Яам тухайн жилд олгосон санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй тулган, мэргэжлийн байгууллагатай хамтран шалгаж дараа оны мөнгийг олгож байх шаардлагатай байна.



/2016 он/



/2017 он/

/Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга/

Х.1.1.18. Булган сумын сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга.

Сургуулийн барилга 2000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын тендерийг БСШУЯ-наас зарлан 1849.0 сая төгрөгөөр бариулахаар Улаанбаатар хотын “Зос трейд” ХХК-тай 2012 оын 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2013 оны 8-р сарын 06-нд дуусгахаар гэрээ байгуулан ажилласнаас 2012 онд 450.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон 2014 онд 354.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байсан.

УИХ-аар төсөвт тусгагдсан дүнг судалж үзэхэд төсөвт өртгийг 2012 оны төсөвт 2000.0 сая, 2013 оны төсөвт 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2300.0 сая төгрөг болгон баталсан, тухайн онд 1000.0 сая төгрөг төсөвт тусгаж өгснөөс бусад мэдээлэл байхгүй байсан.

Барилгын хөгжлийн төвийн 2015 оны 07дугаар сарын 23-ны өдрийн № 740/2015 тоот магадлалаар 2283.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд 207.3 сая төгрөгний эрх нээж 100.0 сая төгрөгний санхүүжилт олгосон, 2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 934.8 сая төгрөгний санхүүжилт олгосон мөн **Векселиэр** мөн ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 107.3 сая төгрөг нэмж давхар авсан ажлын гүйцэтгэл тодорхойгүй байсан.



/2016 он/



/2017он/

/Булган сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга/

2017 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд 1860.0 сая төгрөг тусгагдаж санхүүжилтыг бүрэн авч нийт 4186.4 сая төгрөгний төсөвт өртөгтэй барилгын ажлыг дуусгаж барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдөр байнгын ашиглалтанд хүлээн авсан байна.

Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилга:

Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, сонгон шалгаруулалтыг БСШУЯ-аас 2011 онд зарлаж, тендерт Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК шалгарч барилгын ажлыг гүйцэтгэх 2011 оны 10 дугаар сарын 17-ны 17/2011 тоот гэрээ байгуулж 2013 оны 03 сарын 06-нд ашиглалтанд оруулахаар гарээнд тусгасан, БУ-2011/17+2 тоот гэрээгээр ашиглалтанд оруулах хугацааг 2013 оны 08 сарын 15-ны өдөр гэж өөрчилсөн боловч ямар ажлыг гүйцэтгэж хэдий хэмжээний санхүүжилт авсан нь тодорхойгүй, яамнаас 2011 онд 250.0, 2012 онд 300.0 сая төгрөгийг

дуусаагүй барилгын дансанд бүртгүүлсэн байна. Барилгын ажлын гүйцэтгэл хангалтгүй, аймгийн ГХБХБГ, СТСХ, Боловсрол соёлын газраас тавих хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахаар ажлыг түр зогсоосон 2013, 2014 онд хэдэн төгрөгийн санхүүжилт авсан нь тодорхойгүй байна.

Тэшиг сумын сургуулийн өргөтгөлийн барилгын үндсэн цутгамал төмөр бетон арагт бүтэцийг цутгахдаа тэнхлэгийн хэмжээ алдсан, гадна ханын дүүргэлтийн хөнгөн блокон өрлөгийн ажил хийгдээд ажил бүрэн зогссон, барилгын ажлын гүйцэтгэл 2014 онд аймгийн ГХБХБГ-аас гаргасан дүгнэлтээр ажлын гүйцэтгэл 45 орчим хувьтай байсан.



2015



2016

Тэшиг сум сургуулийн өргөтгөлийн барилга

XI.1.1.41. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд санхүүжих дүн 200.0, гүйцэтгэлээр 78.0 сая төгрөгний санхүүжилт олгосон орон нутагт ирээгүй, тодорхой ажил хийгээгүй гэж ашиглагч байгууллага тодорхойлсон байна.

X.1.1.60. Векселиэр ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 78.0 сая төгрөг нэмж давхар санхүүжилт авсан боловч 2016 онд Тэшиг суманд ирж ажиллаагүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй, орон нутгийн ГХБХБГазраас тодорхой хяналт тавиагүй гэрээний хугацаа дууссан байна. 2017 онд огт ажил хийгээгүй байна.

Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК нь ЗТБХБС-ын 2012 оны 18, 181-р тушаалуудын дагуу төсөвт өөрчлөлт оруулж өгөхийг хүссэн, холбогдох байгууллага авч хэлэлцээгүй, гэрээ сунгаагүй байна. Барилга угсралтын ажлын төсвийг Барилга хөгжлийн төвийн магадлалаар оруулж 2017 оны 11 сарын 03-ны өдрийн 82/2017 тоот дүгнэлтээр үлдэгдэл ажлыг 506.8 сая /506778657/ төгрөгөөр шинэчлэн баталгаажуулсан 2018 оны төсөвт 200.0 сая төгрөг тусгуулсан байна.

X.2.1.14. Баян-Агт сумын соёлын төвийн барилга.

Соёлын төвийн барилгын хөрөнгө оруулалтын тендерийг БСШУЯ-аас 2011 онд зарлаж 700,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2012 оны 11 сарын 25-ны өдөр хийж дуусгахаар Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

Соёлын төвийн барилгын ажил 2011-2012 онуудад өрлөгийн ажил дуусаж, 2013 онд дээвэр, шалны цутгалтын ажил хийгдсэн, БСШУЯамнаас 2011 оны

жилийн эцсийн тайлангаар 300.0 сая төгрөгийг, 2012 онд 240.0 төгрөгийг дуусаагүй барилгаар бүртгүүлж боловсрол соёлын салбарын нэгдсэн тайлан балансад тусгуулжээ.

Барилгын ажлын төсөвт өртөгийг 590.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулж 2014, 2015 онд барьж байгуулан ашиглалтанд оруулж улсын комисст хүлээлгэн өгсөн. Санхүүжилтийн зөрүү 301.8 сая төгрөгийг 2016 онд олгоогүй, 2017 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тусгаж авсан боловч хийхээр тохирсон Галын дохиолол, Цэвэр бохирын шугам холбох ажил, Худаг гаргах, Зогсоолын гэрэлтүүлэг зэрэг дутуу ажлыг одоо хүртэл хийж гүйцэтгээгүй зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлжээ. Аймгийн ГХБХБГ-ын дүгнэлт тодорхойлолтыг хавсаргав.

Х.4.1.11. Хангал сумын Хялганат тосгоны спортын заалны барилга.

Хангал сумын Хялганат тосгоны биеийн тамирын заалны барилга нь 1083,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээс эхний шатны ажилд 2012 онд 250,0 сая төгрөг төсөв батлагдан, сонгон шалгаруулалтанд 4 компани материал ирүүлснээс “Од” ХХК хамгийн бага үнийн санал ирүүлсэн боловч өмнө нь хийж байсан ажлын чанар, одоогийн хийх хугацаа зэргийг харгалзан гишүүдийн олонхийн /4 хүний/ саналаар Улаанбаатар хотын “Бат ван” ХХК-ийг сонгож 12-р сарын 03-ны а/392 тоот захирамжаар эрх олгосноор 12-р сард багтаан барилгын улаан шугам тавих буюу зураг төслийн байгууллагатай зөвшилцөн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх аргачилал боловсруулахаар гэрээ байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2013 оны 3-р сарын 05-ны өдрийн А/91 тоот захирамжийн дагуу Улаанбаатар хотын Төв тооцооны төвийн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн 3-р сарын 27-нд үлдэгдэл санхүүжилт 179.3 мянган төгрөг буюу нийт санхүүжилтийг 100 хувь олгон 1-р шатны ажлыг улсын комисс хүлээн авсан байна.

Барилгын ажлыг “Нью сувагт констракшн” ХХК гүйцэтгэж байгаа 2015 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 589.3 сая төгрөгний эрх нээсэн, төрийн сангаас 350.0 сая төгрөгний санхүүжилт олгосон ажлын гүйцэтгэл тодорхойгүй,

Х1.4.1.12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд гүйцэтгэлээр 589.4, сая төгрөгний санхүүжилт авч ажил гүйцэтгэсэн,

Х.4.1.9. Векселиэр ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 239.3 сая төгрөг нэмж давхар авсан ажлын гүйцэтгэл тодорхойгүй, гэрээний хугацаа дууссан.

2017 онд Засгийн газрын 69 дүгээр тогтоолын дагуу нэмэгдэл санхүүжилт 296.6 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тусгуулан санхүүжилтийг бүрэн олгож барилгын ажлыг дуусгаж барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байнгын ашиглалтанд хүлээн авсан байна.

Б.4.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн их засварын зарим ажлын гэрээний хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын их засварын төсөл, арга хэмжээнд 2017 онд 411.5 сая төгрөгний төсөвт өртөгтэй ажлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөж,

аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн байна. Хууль журмын дагуу ажил тус бүрт нээлттэй тендер зарлан, сонгон шалгаруулалт явуулж их засварын 5 ажлыг нийт 313.1 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж болон авто машин нийлүүлэх 5 ажлыг 98.4 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр шалгарсан компаниудтай гэрээ байгуулан ажлыг эхлүүлж аймгийн ГХБХБГ их засварын ажлын явцад тогтмол хяналт тавьж засварын ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэн ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

X.1.2.1.1.5 Булган аймгийн Могод сумын соёлын төвийн их засвар:

Могод сумын Соёлын төвийн их засварын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 140.0, орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс 67.4, нийт 207.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж УБ хотын “Элэг бүс” ХХК тендерт шалгарч ажил гүйцэтгэх гэрээг 2017 оны 07 дугаар ын 19-ний өдрөөс хойш 60 хоногийн дотор гүйцэтгэнэ гэж гэрээ байгуулан гэрээнд тусгагдсаны дагуу 40 хувь буюу 82.9 сая төгрөгийг ХААН банкны 5040146377 тоот дансанд шилжүүлж үлдэгдэл санхүүжилтыг 5 хувааж 124.5 сая төгрөгийг олгосон байна.

“Элэг бүс” ХХК нь гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгэж дуусаагүй, 41 хоног хэтрүүлсэн, гэрээний тусгай нөхцөлийг тусгаагүй гэрээ байгуулсан, хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлага болон алданги тооцох талаар тусгаагүй, ажил хүлээлцсэн комиссын гишүүд нь 2017 оны 10 дугаар сарын 31-ны өдөр ажлын хэсэг 18 тоот дүгнэлтээр гүйцэтгэгч байгууллагад 8 ажлын үүрэг даалгавар өгч үүрэг даалгаварын биелэлтийг хэд хоногийн хугацаатайгаар хяналт тавьж ажлын даалгаварыг хүлээж авсан тухай тайлан, тэмдэгдэл байхгүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

XII.1.2.1.1.164 Сэлэнгэ сумын сургуулийн дотуур байрны засварын

ажил:

Сэлэнгэ сумын сургуулийн дотуур байрны засварын ажил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж “Төгөл моностой” хоршоо тендерт шалгарч 2017 оны 12 сарын 15-ны өдрөөс 6 хоногийн хугацаатай, 10.0 сая төгрөгөөр хийж дуусгаахаар гэрээ байгуулан хугацаанд нь гүйцэтгэн актаар хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн төрийн сангийн хэлтэс нь Монгол улсын БСШУССайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/372 тоот тушаалаар Сэлэнгэ сумын сургуулийн дотуур байрны засварын 10.0 сая төгрөгийн эрх шилжиж ирсний дагуу 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр “Төгөл моностой” хоршооны 5280001143 тоот данс руу 10.0 сая төгрөгийг шилжүүлжээ.

XII.1.2.1.1.72 Булган аймгийн Дашинчилэн сумын 320 хүүхдийн бүрэн дунд сургуулийн дээврийн засварын ажил:

Дашинчилэн сумын 320 хүүхдийн суудалтай бүрэн дунд сургуулийн барилгын дээврийн засварын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 70.0, орон нутгийн төсвөөс 24.6, нийт 94.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж гүйцэтгэгч компанийг УБ хотын “Онъ тэнгэрийн бичиг”

ХХК-ийг тендерт шалгаруулан, 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 61/2017 тоот гэрээ хийж ажлыг 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүлээлгэн өгөхөөр нийт 94.6 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж санхүүжилтыг 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 60.0, 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 10.0 сая төгрөг буюу ажлын гүйцэтгэл 73 хувьтай гэж үзэн нийт 70.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруултаас, аймгийн орон нутгийн төсвөөс 20.8 сая төгрөгийг шилжүүлж батлагдсан төсвөөс 3.8 сая төгрөгийн дутуу санхүүжилт авчээ.

Дээрхи ажлын гүйцэтгэлийг гүйцэтгэгч компани нь 22 хоног хэтрүүлж ашиглалтанд өгсөн, мөн ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийг гэрээнд тусгаагүй, хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлага тооцох талаар тусгаж гэрээ байгуулаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

XII.1.2.1.1.75 Хөгжимт жүжгийн театрын барилгын засварын ажил:

Аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгын засварын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 36.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, тендер шалгаруулах ажлыг зохион байгуулан Булган аймгийн “Хурмастын хүлэг” ХХК-ийг сонгон шалгаруулж 2017 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 23 хоногийн хугацаатай ажлыг гүйцэтгэж санхүүжилтыг ажлын 50 хувийн гүйцэтгэлээр олгоно гэж гэрээнд тусгасан боловч гэрээний дагуу санхүүжилт олгоогүй санхүүжилтыг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр 35.7 сая төгрөгийг шилжүүлж, зураг төсвийн 1.2 сая төгрөгийг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Тэнүүн асар” ХХК-ий данс руу шилжүүлэн ажилласан байна.

Ажил хүлээлцэх комисс 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авчээ.

Нэгдсэн эмнэлэгийн А блокны засварын ажил:

Нэгдсэн эмнэлгийн А блокны засварын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 56.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон тендер шалгаруулах ажил зохион байгуулж “Бүлээн оргил” ХХК-ийг шаардлага хангахгүй гэсэн комиссын дүгнэлт гарч аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэний дагуу Засаг дарга 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/472 тоот мэдэгдлээр ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27.4 “энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэж заасны дагуу гэрээ байгуулах боломжгүй гэсэн хариуг “Бүлээн оргил” ХХК-д хүргүүлсэн боловч 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/222 тоот гэрээ байгуулах захирамж гарч “Бүлээн оргил” ХХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 30 хоногийн хугацаатайгаар нийт 56.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Санхүүжилтыг 2017 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр магадлашгүй ажлын зардалд 0.9, 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 22.5, 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдөр 32.8 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн ажиллажээ.

Уг засварын ажлыг хүлээлцэх комисс 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авч гүйцэтгэгч компани нь 38 хоногоор хэтрүүлж гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй, хугацаа хэтэрсэн байна.

Цаашид ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6.1.”Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх

зарчмыг баримтална.”, 46.1.3.”үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах;” гэсэн заалт зарчмыг баримталж ажиллах шаардлагатай.

III.1.2. Аймгийн ЗДТГ-ын барилга:

Булган аймгийн ЗДТГ-ын барилгын ажлын санхүүжилтийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Түмэн алт” ХХК-ий 5003004799 тоот дансруу 143.4, 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 10.5 сая төгрөгийг тус тус нэхэмжлэх баримтаар шилжүүлсэн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 153.9 сая төгрөгийн анхан шатны болон санхүүгийн баримт, гэрээ, захирамж болон бусад баримтууд байхгүй зөрчил илэрлээ.

IV.3.1.4. Булган аймгийн Баяннуур сумын ЗДТГ-т автомашин:

Булган аймгийн Баяннуур, Могод сумдын ЗДТГ-т шаардлагатай байгаа авто машин нийлүүлэх ажил 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийлүүлэгчийг сонгон шалгаргуулах үнэлгээний хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/629, А/630 тоот шууд гэрээ байгуулах захирамжын дагуу Булган аймгийн “Хурмастын хүлэг” ХХК-тай гэрээ байгуулж ЗГХЭГДаргын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 282 тоот тушаалын дагуу аймгийн төрийн сангийн хэлтэст эрх шилжин ирж 70.0 сая төгрөгийг оны эцэс болсонтой холбогдуулан орон нутгийн нэмэлт 100040051499 тоот дансанд төвлөрүүлэн 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Баяннуур сумын ЗДТГ-ын 100041555405 тоот дансанд 35.0, 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Могод сумын 100040655405 тоот дансанд 35.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

Дээрхи 2 сумдын гүйцэтгэлийг үзэхэд Могод сум нь авто машин худалдан авах гэрээг 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр иргэн Ц.Лхагвасүрэнтэй 39.0 сая төгрөгөөр байгуулж Ланд-100 маркын автомашин худалдан авсан нь аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/629 тоот захирамжын дагуу гэрээг байгуулаагүй, нийт үнийн дүнг 4.0 сая төгрөгөөр илүү тооцсон, ХХОАТ болох 3.9 сая төгрөгийг татварт шилжүүлээгүй, үнийн санал авч баримтжуулаагүй зэрэг зөрчил илэрсэн тул суутган тооцож шилжүүлээгүй 3.9 сая төгрөгийн төлбөрийн акт бичлээ.

Баяннуур сумын ЗДТГ нь аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/629 захирамжын дагуу гэрээ хийсэн автомашин нийлүүлэх “Хурмастын хүлэг” ХХК-ны 5270578043 тоот данс руу 2017 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 35.0 сая төгрөг шилжүүлсэн боловч тухайн компани нь авто машин нийлүүлээгүй “Хурмастын хүлэг” ХХК-ны дансаар 35.0 сая төгрөгийг дамжуулан УБ хотын иргэн Н.Ёндонжамцаас Ланд крузер-120 маркын 2014 оны авто машин худалдан авч “Хурмастын хүлэг” ХХК ХХОАТ 10 хувийг хасаж тооцон 31.5 сая төгрөгийг шилжүүлсэн зөрчил илэрсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 41.2. “Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн.

Хангал, Сэлэнгэ, Рашаант сумдын ЭМТ-үүдийн халаалтын тогоо солих, сантехник, цахилгааны засварын ажил:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны Эрх шилжүүлэх тухай А/434 тоот тушлаалуудаар дээрхи 3 сумдын ЭМТ-үүдийн цахилгаан, сантехникийн засвар,

халаалтын тогоо солих ажлын санхүүжилт 23.0 сая төгрөгөөр эрх батлагдаж аймгийн ЭМГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/46 тоот тушаалаар тендер шалгаруулалтын ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллажээ.

Ажлын хэсэг хуралдаж Сэлэнгэ сумын ЭМТ-ийн халаалтын тогооны засварын 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Долоон бар” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдөр 5 хоногийн хугацаатай, Хангал сумын ЭМТ-ийн цахилгааны засварын 7.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “ЭС ЭМ ДИ ЖИ” ХХК-тай 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр 5 хоногийн хугацаатай, Рашаант сумын ЭМТ-ийн сантехникийн засварын 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Цахим хүч” ХХК –тай 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдөр 5 хоногийн хугацаатай гэрээг тус тус байгуулж ажлын комисс ажил хүлээлцэх актаар дээрхи ажлуудыг хүлээн авч холбогдох санхүүжилтыг гэрээнд тусгагдсан данс руу холбогдох санхүүжилтыг шилжүүлэн ажилласан байна.

ЭМГ нь төсвийн хуваарилалт хийхдээ Хангал, Сэлэнгэ, Рашаант сумдын ЭМТ-үүдээс шаардагдаж байгаа хөрөнгийн төсвийг төсөвлөөгүй, санхүүжилтийг шууд хуваарилсан, аймгийн төрийн сангийн хэлтэс нь санхүүжилтийг олгохдоо дээрхи ажлуудын засварын ажлын батлагдсан төсөвгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүйгээр гүйцэтгэсэн газрын нэхэмжлэх баримтаар санхүүжилтийг олгосон, барааны үнийн саналыг баримтжуулаагүй амаар болон утсаар үнийн саналыг асуусан зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь худалдан авах ажиллагааны журмын 46.1.4” худалдан авах бараа ажил үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөн зохион байгуулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Техник хэрэгслийн ажил:

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/453 дугаар эрх шилжүүлэх тушаалыг үндэслэн ЭМГ нь 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдөр “ЮУ БИ МОТО” ХХК-тай тээврийн хэрэгсэл худалдах, худалдан авах №ЭМГ/01 тоот гэрээг байгуулж UB-150 маркын 3 ширхэг мотоциклийг нийт 5.4 сая төгрөгөөр худалдан авч 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр “Юу би мото” ХХК-ий 5009815588 тоот дансанд 5.4 сая төгрөгийг шилжүүлжээ.

Гурванбулаг сумын ЭМТ-д UB-150 маркын 2 ширхэг мотоциклийг хүлээлгэн өгч тус сумын ЭМТ нь өөрийн байгууллагын данс бүртгэлд бүртгэн тайлагнасан, үлдэгдэл 1 ширхэг мотоциклийг Могод сумын ЭМТ-д хуваарилсан боловч ирж аваагүй гэсэн шалтгаанаар оны эцсийн тайлан бүртгэлд тусгагдаагүй орхигдсон зөрчил илэрсэн тул Могод сумын ЭМТ-ийн тайлан бүртгэлд 1.8 сая төгрөгийн өртөгтэй мотоциклийг орлогод бүртгүүлэхээр аймгийн ЭМГ-т албан шаардлага бичлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хэрэгжсэн барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийн аудитаар нийт 149.2 сая төгрөгний алдаа зөрчил илэрч 3.9 сая төгрөгт акт тогтоож 1.8 сая төгрөгт албан шаардлага бичиж, аймгийн Засаг дарга, ГХБХБГ, СТСХ, ОНӨГ-ын дарга нарт ажил сайжруулах зөрчлийг арилгуулах 9 хугацаатай зөвлөмж хүргүүлжээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- Аймаг 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нэг ч ажил шинээр төсөвт нэмж тусгагдаагүй, өмнөх онуудаас хэрэгжиж байгаа 16971.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээний 4 төсөл арга хэмжээг ашиглалтанд хүлээж авсан, 2 ажил нь олон жил он дамжин хэрэгжиж байгаа гүйцэтгэгч ажлаа бүрэн гүйцэд хийгээгүй, хугацаа сунгаж нэмэлт төсөв шаардаж санхүүжсэн,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтанд орсон Баян-Агт сумын Соёлын төвийн зарим ажил дутуу 2015 онд ашиглалтанд орсон 301.8, Хялганат тосгоны Спортын заал 2016 онд ашиглалтанд орсон 296.6 сая төгрөгийг тус тус 2017 оны төсөвт тусгаж санхүүжилт авсан боловч орон нутагт ямар ч мэдээлэл байхгүй, эрх шилжиж ирээгүй,
- Булган сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтанд орж улсын комисс хүлээн авахад 47 ажил чанаргүй дутуу хийгдсэнд хугацаатай үүрэг өгсөн боловч дээрхи ажлаас 10 ажлыг хийж бусад ажлыг хийгээгүй,
- Аймгийн Засаг даргын тамгын газрын барилга 2012 онд ашиглалтанд оруулах гэрээ байгуулсан боловч 5 жил хугацаа хэтэрсэн, улсын комисс 2017 онд хүлээж авсан, барилгын ажлын чанар хангалтгүй, барилга хагарал үүссэн, ус гоожсон, “Г” блокны ажил одоо болтол дуусаагүй,
- Аймагт эрх нь шилжиж ирээгүй салбарын чиглэлээр орон нутагт баригдаж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилгын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул, орон нутгийн оролцоо хангалтгүй,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа их засварын ажлыг ажил гүйцэтгүүлэх компанитай ГХБХБГ төлөөлөл гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч гэрээний тусгай нөхцлөөр хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох болон алданги тооцож ажиллах тухай гэрээнд тусгаагүй, Сангийн сайдын 2007 оны 268 тоот хавсралтын журмын 2.“Гэрээний маягт” зааврын 5 дахь заалтын дагуу гэрээг байгуулаагүй,
- Могод сумын соёлын төвийн их засварын ажлыг “Элэг бүс” ХХК нь 41 хоногоор, Дашинчилэн сумын 320 суудалтай сургуулийн их засварын ажлыг “Онъ тэнгэрийн бичиг” компани нь 22 хоногоор, Нэгдсэн эмнэлэгийн А блокны засварын ажлыг “Бүлээн оргил” ХХК нь 38 хоногоор тус тус хэтрүүлэн гэрээний хугацаандаа ажлыг хүлээлгэн өгөөгүй,
- Могод сумын соёлын төвийн их засварын ажлыг хүлээн авах комиссын гишүүд нь 2017 оны 10 дугаар сарын 31-ны өдөр ажлын хэсэг 18 тоот дүгнэлтээр гүйцэтгэгч байгууллагад 8 ажлын үүрэг даалгавар өгч үүрэг даалгаварын биелэлтийг хэд хоногийн хугацаатайгаар хяналт тавьж ажлын даалгаварыг хүлээж авсан тухай тайлан, тэмдэгдэл байхгүй,ажлын явцад хяналт хийсэн тайлан биелэлтээр аймгийн төрийн сангийн хэлтэс хянаж ГХБХБГ-ын зөвшөөрлын дагуу санхүүжилтыг олгож хэвшээгүй,
- Нэгдсэн эмнэлэгийн А блокны засварын тендер шалгаруулах ажлын хэсэг нь “Бүлээн оргил” ХХК-ийг шаардлага хангахгүй гэсэн комиссын дүгнэлт гаргаж аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэний дагуу Засаг дарга 2017 оны 04

дүгээр сарын 06-ны өдрийн 01/472 тоот мэдэгдлээр ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27.4 “энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэж заасны дагуу гэрээ байгуулах боломжгүй гэсэн хариуг “Бүлээн оргил” ХХК-д хүрүүлсэн боловч 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/222 тоот гэрээ байгуулах захирамж гарч “Бүлээн оргил” ХХК-тай 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 30 хоногийн хугацаатайгаар нийт 56.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан,

- Могод сумын ЗДТГ нь автомашины худалдах авах гэрээг 35.0 сая төгрөгөөр байгуулаагүй батлагдсан төсвөөс 4.0 сая төгрөгөөр илүү гэрээ байгуулж ХХОАТ-ыг болох 3.9 сая төгрөгийг орон нутгийн татварт шилжүүлээгүй,
- Баяннуур сумын ЗДТГ нь аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/629 тоот захирамжын дагуу “Хурмастын хүлэг” ХХК-тай гэрээ хийсний дагуу дээрхи компаний дансруу 35.0 сая төгрөг шилжүүлсэн боловч уг компани нь авто машин нийлүүлээгүй, УБ хотын иргэн Н.Ёндонжамцын тоот данс руу 31.5 сая төгрөгийг шилжүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 41.2.”Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн,
- Хангал, Сэлэнгэ, Рашаант сумын ЭМТ-үүдийн халаалтын тогоо солих, сантехник, цахилгааны засварын ажлуудын нийт 23.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын санхүүжилтыг олгож хуваариалахдаа шаардагдаж байгаа хөрөнгийн төсөв хийгдээгүй, үнийн санал аваагүй,
- Улсын төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж нийлүүлэх 5.4 сая төгрөгийн ажлыг Гурванбулаг сумын ЭМТ, Могод сумын ЭМТ-ийн багийн эмч нарт нийлүүлэх 3 мотоциль худалдан авсан боловч Могод суманд нийлүүлэх 1 мотоциклийг бүртгэл тайланд бүртгээгүй хүлээлгэн өгөөгүй,
- Төсөл арга хэмжээний тендерийн ажлын сонгон шалгаруулалтанд худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд томилогдсон гишүүний ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг бүрэн бус, гарын үсэг дутуу, иргэний төлөөллийг оролцуулаагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4 дэхь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 15.3.4, 16.1.2, 21.1, 34.2 дэхь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- Булган сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2 км авто замын ажлыг “Хур ноёд” ХХК гүйцэтгэж дутуу орхисон ажлыг Шүүхээс албадан гүйцэтгүүлэх тухай 2015 оны сум дундын шүүхийн 935 тоот захирамж гарсан боловч 265.9 сая төгрөгний ажлыг одоо хүртэл хийж гүйцэтгээгүй, өмнөх зөвлөмж хэрэгжээгүй байна.

2011 оноос эхлэн хөрөнгө оруулалтаар олон жил баригдаж байгаа барилгын тендер яаманд зарлагдсан, орон нутагт эрх шилжиж ирээгүй, жил бүр санхүүжилт авдаг санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулж олгоогүй, барилгын ажил удааширсан зэргээс үзэхэд хөрөнгө оруулалтын ажил үр дүн муутай, аймгийн удирдлага, мэргэжилийн байгууллагаас тавих хяналт сул байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг дарга З.Батзориг, СТСХ-ийн дарга О.Наранжаргал нарт:

1. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, олон жил он дамжин баригдаж байгаа Булган сумын 640 хүүхдийн суудалтай 1-р сургууль, Тэшиг сумын сургуулийн өргөтгөлийн барилга зэрэг жил бүр санхүүжилт авдаг ажлын гүйцэтгэл тодорхойгүй, удаашралтай байгаа ажлуудад дүгнэлт хийж, мэргэжлийн байгууллагуудын тавих хяналт шалгалтын ажлыг сайжруулж тодорхой арга хэмжээ авах,
2. Аймгийн хөгжлийн бодлого, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр барих барилга байгууламжийг тусгах, хөрөнгө оруулалттай холбоотой тогтоол шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах,
3. Улсын комисс хүлээж авсан аймгийн ЗДТГазар, Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлын дутуу, чанаргүй хийгдсэн ажлуудыг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтанд хүлээн авах арга хэмжээг зохион байгуулах,
4. Аймагт эрх шилжин ирсэн их засврын ажлын гэрээ, гүйцэтгэл, санхүүжилтыг олгохдоо холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

ГХБХБГ-ын дарга Ү.Бямбасүрэн, Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Батжаргал нарт:

5. Мэргэжлийн байгууллагын зүгээс Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилгын ажлын санхүүжилтийн үе шат бүрт тавих хяналтыг сайжруулах, барилгыг гэрээнд заасан хугацаанд компаниар хийж гүйцэтгүүлэх, барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулан, гүйцэтгэлийг бодитойгоор тооцож Сангийн сайдын 290-р тушаалын 3.3 дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллах,
6. Тендерт оролцогч болон аливаа этгээд нь гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй тохиолдолд тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах арга хэмжээ авч ажиллах,
7. ТБОНӨХБАУХАТ хуулийн 15.3.4, 16.1.2, 21.1, 34.2 дахь заалтыг мөрдөж ажиллах,
8. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна сумын Засаг дарга, байгууллагын дарга нарт эрх шилжсэн төсөл арга хэмжээний тендерийн ажлын сонгон шалгаруулалтанд хяналт тавьж, зөвлөмж өгч тайлан мэдээнд оруулах,

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллан 2018 оны 09 дүгээр сарын 30-ны дотор хариу ирүүлэхийг мэдэгдэе.

ТАНИЛЦСАН:

**АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

Д.АНХБАЯР

